*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*6 дугаар хавсралт*

# ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ МӨНХБААТАР ОВОГТОЙ АМАРЗАЯАГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. “Олон улсын худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хангах” зорилтын хүрээнд** | | | | | | | |
| 1. | Гаалийн хяналтад эрсдэл тооцож дүн шинжилгээ, судалгаа хийж, үр дүнг тооцох | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Гаалийн хяналтад эрсдэл тооцож дүн шинжилгээ, судалгаа хийж, үр дүнг тооцох ажлын хүрээнд төрөлжсөн судалгаа хийсэн байна.<br>/I-IV улирал/ | Гаалийн хяналтад эрсдэл тооцож дүн шинжилгээ, судалгаа хийж, үр дүнг тооцох тус ажлын хүрээнд нийт 13 судалгааг хийсэн.<br>1. Гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд итгэмжлэлээр аж ахуйн нэгжийг төлөөлж гаалийн харилцаанд оролцогч төлөөлөгчийн судалгааг хийсэн. Үүний үр дүнд:<br>· Судалгаа, дүн шинжилгээ хийх загварыг боловсруулсан;<br>· ЗТГ-т 2024.02.16-ны өдрийн 2024/30 дугаар дотоод зурвасаар эрсдэл тооцож ажиллах буюу аж ахуйн нэгж, иргэдийн харилцан хамаарлыг тодорхойлж, өндөр эрсдэл бүхий ачилтыг бууруулахад талаар хүргүүлсэн;<br>· БДШГ-т 2024.02.21-ний өдрийн 2024/32 дугаар дотоод зурвасаар эрсдэл тооцож ажиллах буюу судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжийн хувьд худалдааны луйвар гаргах эрсдэл өндөр байгаа тул судалгаатай танилцан, тогтмол хугацаанд бүрдүүлэлт хийдэг, зөрчил гаргасан, өндөр эрсдэл бүхий 259 аж ахуйн нэгжийг бүрдүүлэлтийн дараах шалгалт хамруулах талаар хүргүүлсэн;<br>· ЗҮГГ-ын ЭУА-нд эрсдэл тооцож ажиллахаар судалгааг хүргүүлсэн.<br>2. УБГГ-ын 2024.01.15-ний өдрийн 01/24 дугаар албан бичгээр ирүүлсэн Зөвшөөрөгдсөн шалгуурт оруулах 10 ААН-ийн судалгааг хийж, шалгуурт байхгүй ААН-ийн хууль сахилтын түвшин болон бараанд эрсдэл тооцуулахаар БДШГ, ХЦХ | 2024.01.01-2024.12.10 | 98 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | болон ГТЛ-тай хамтран ажиллаж, шалгуурт оруулсан. Судалгаагаар:<br>· ХЦХ-т 2024.01.30-ны өдрийн 2024/21 дугаар дотоод зурвасаар 2 ААН-ийг “Зөвшөөрөгдсөн шалгаар”-т ААН, бараагаар хослуулан оруулж болох талаар;<br>· ГТЛ-т 2024.01.30-ны өдрийн 2024/22 дугаар дотоод зурвасаар нэг ААН-ийн “Тосолгооны материал”-ыг гаалийн лабораторийн магадлан шинжилгээний үр дүнгээр эрсдэл тооцох талаар;<br>· БДШГ-т 2024.02.06-ны өдрийн 2024/25 дугаар дотоод зурвасаар нэг ААН-ийн хууль сахилтыг тодорхойлоход бүрдүүлэлтийн дараах шалгалтын үр дүн шаардлагатай тул судалгааг хүргүүлж ажилласан.<br>3. Гадаад худалдааг хөнгөвчлөх ажлын хүрээнд 2023 онд БТКУС-ийн 8703 кодод хамаарах суудлын автомашины бүрдүүлэлтийн цаг хугацаа өмнөх оноос хэрхэн буурсныг тодорхойлох зорилгын хүрээнд судалгааг хийж, удирдлагад танилцуулсан.<br>4. ОУВСангийн зөвлөхүүдэд хяналтын төлөвийн хэрэгжилт болон программд хэрэгжиж буй эрсдэлийн шалгуурын судалгааг хийж, хүргүүлсэн.<br>5. Гаалийн мэдүүлгийн шалгалтын үр дүнгийн саналын судалгааг 2024 оны нэгдүгээр улирлын байдлаар хийж, удирдлагад танилцуулан, ШҮДС-ыг үр дүнтэй, оновчтой бичих талаар ГГХ-дод цахимаар чиглэл, санамжийг өгсөн.<br>6. ЧХОУНБГГ-аас 2024.03.04-ний өдрийн 01/128 тоот албан тоотоор ирүүлсэн БДШ-д хамруулах ААН-ийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, гаалийн зөрчил, шалгалтын үр дүнгийн санал бичигдсэн эсэх талаар тулган шалгаж, 20 ААН-д эрсдэл тооцож, БДШ хийх боломжтой эсэх талаар 2024.04.08-ны өдрийн 2024/63 дугаар дотоод зурвасаар БДШГ-т хүргүүлсэн.<br>7. БТКУС-ийн 2404 кодод хамаарах “Электрон тамхи” импортлогч аж ахуйн нэгжүүдэд дүн шинжилгээг хийж, гаалийн зөрчил, шалгалтын үр дүнгийн саналаар 16 ААН-д эрсдэл тооцож, БДШ-ыг хэсэгчилсэн болон иж бүрэн байдлаар хийлгэх жагсаалтыг хүргүүлж ажилласан.<br>8. ЧХОУНБГГ-ын 2024.05.03-ны өдрийн 01/293 дугаар албан тоотоор Турк улсаас гоёл чимэглэл, бэлэн хувцас, гэр ахуйн бараа импортолдог, өндөр эрсдэл бүхий 3 аж ахуйн нэгжид БДШ оруулахаар 2024.06.04-ний өдрийн 2024/106 дугаар дотоод зурвасаар хүргүүлсэн. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 9. Гаалийн байгууллагын гадаад хдалдааны гүйцэтгэлийг 2018-2023 оны хооронд хийж, бараа эргэлтийг ГГХ-оор гаргаж, татварын орлогын төлөвлөгөө, биелэлтэд дүн шинжилгээг хийж, удирдлагад танилцуулсан.<br>10. ГЕГ-ын даргын 2024.06.06-ны өдрийн А/339 тушаалаар батлагдсан Гаалийн байгууллагын улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг хангуулахад чиглэсэн ажлын хэсгийн Судалгаа, дүн шинжилгээний багт ажиллаж, барааны бүлгээр, статистик үзүүлэлтээр барааны үнийн өсөлт, бууралтын шалтгааныг тогтоох зорилгоор 6 дүн шинжилгээг хийж, танилцуулж ажилласан.<br>11. "Оюу толгой" ХХК-ийн хууль сахилтын түвшний судалгааг хийж, дэд даргад танилцуулсан.<br>12. ГЕГ-ын даргын 2024.09.20-ны өдрийн "Говь" ХК, "АПУ" ХК, "Ханбогд Кашимер" ХХК-д гаалийн итгэмжлэл олгох шалгуурыг үнэлэх, баталгаажуулах ажлын удирдамжаар "Санхүүгийн чадавхи"-д баталгаажуулалт хийхэд тус 3 ААН-ийн гаалийн бүрдүүлэлт болон санхүүгийн үзүүлэлтэд дүн шинжилгээ хийж, баталгаажуулсан.<br>13. БЦТ-ийн 2024.12.02-ны өдрийн 175 дугаар дотоод зурвасаар ирүүлсэн санал (Экспортын бүрдүүлэлтийн 100 горимоос бусад горимыг ЭУ-ийн заавал шалгах шалгуурт оруулах)-д дүн шинжилгээг хийж байна. | | |
| 2. | Гаалийн хяналтад эрсдэл тооцох ажлын хүрээнд өөрийн хариуцсан газар хорооны эрсдэлийн профайл, эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн баяжилтыг хийж, эрсдэлийн удирдлагын программд оруулна. | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Эрсдэлийн дүн шинжилгээ хийж, хариуцсан газар хорооны эрсдэлийн профайл, эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн баяжилтыг хийсэн байна.<br>/I-IV улирал/ | Тайлант хугацаанд УБГГ, ЧХОУНБГГ болон БДШГ-ын 13 "Эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн хүсэлт"-ийг үндэслэн 48 хяналтын хуудас боловсруулж, ААН-ийг БТКУС код, ГГХ-той уялдуулж, зохих шалгуурт оруулж, эрсдэлийн профайл, эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн баяжилтыг хийсэн. Үүнд:<br>1. Хорио цээрийн хэлтсийн 2023.12.08-ны өдрийн 421 дугаар дотоод зурвасаар ирүүлсэн Эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн хүсэлтийг үндэслэж БТКУС-ийн 4 кодоор, хяналтын хуудас № 191;<br>2. УБГГ-ын 2024.01.15-ны өдрийн 01/24 дугаар албан бичиг "Эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн хүсэлт", Хорио цээрийн хэлтсийн 2024.02.02-ны өдрийн 42 дугаар дотоод зурвасыг үндэслэж ААН-ийг БТКУС кодтой уяж, хяналтын хуудас № 193;<br>3. 2023 оны хяналтын хуудас 157 тоотоор оруулсан зарим барааны дүн шинжилгээний үр дүнгээр Зөрчлийн тухай | 2024.01.01-2024.12.10 | 98 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хуулийн 11.21 дүгээр зүйлийн 1.1 болон 1.2 дахь заалтыг зөрчсөн тул БТКУС-ийн 2 кодыг эрсдэлийн шалгуураас хасах, хяналтын хуудас № 204;<br>4. Зөрчлийн тухай хуулийн 11.21 дүгээр зүйлийн 1.1 болон 1.2 дахь заалтыг үндэслэн, БТКУС-ийн 2 кодоор, хяналтын хуудас № 205;<br>5. УБГГ-ын 2024.02.27-ны өдрийн 01/126 дугаар албан бичиг “Шинэ автомашины судалгаа”-г үндэслэж, ААН-ийг БТКУС кодтой уяж, хяналтын хуудас № 217-232;<br>6. БДШГ-ын 2024.04.19-ний өдрийн 81/24 дугаар дотоод зурвас “Эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн хүсэлт”-г үндэслэж, ААН-ийг ГГХ-той уяж, хяналтын хуудас № 244-259;<br>7. УБГГ-ын 2024.05.09-ний өдрийн 01/411 дугаар албан бичиг “Эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн хүсэлт”-г үндэслэж, ААН-ийг БТКУС код болон ГГХ-той уяж, хяналтын хуудас № 267-268;<br>8. ЧХОУНБГГ-ын 2024.05.03-ны өдрийн 01/293 дугаар албан бичиг “Эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн хүсэлт”-г үндэслэж, ААН-ийг системийн хэмжээнд, хяналтын хуудас № 279;<br>9. УБГГ-ын 2024.06.05-ны өдрийн 01/496 дугаар албан бичиг “Эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн хүсэлт” болон ХЦХ-ийн 2024.06.05-ны өдрийн 183 дугаар дотоод зурвасыг үндэслэж, ААН-ийг БТКУС код болон ГГХ-той уяж, хяналтын хуудас № 280 эрсдэлийн шалгуурт оруулсан.<br>10. УБГГ-ын 2024.06.13-ны өдрийн 01/534 дугаар албан бичиг “Эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн хүсэлт”-г үндэслэж, ААН-ийг БТКУС код, гарал үүсэл, ГГХ-той уяж, хяналтын хуудас № 286;<br>11. Хяналтын хуудас №247-г шинэчилж, БТКУС кодыг оруулж, хяналтын хуудас № 287-288;<br>12. БДШГ-ын 2024.06.18-ны өдрийн 115/24 дугаар дотоод зурвас “Эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн хүсэлт”-г үндэслэж, 25 ААН-ийг шалгуурт оруулсан, № 297-301;<br>13. БДШГ-ын 2024.11.01-ний өдрийн 185/24 дугаар дотоод зурвас “Эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн хүсэлт”-ийг үндэслэж, ААН-ийг системийн хэмжээнд, хяналтын хуудас № 371; | | |
| 3. | Эрсдэлийн судалгаа, дүн шинжилгээний үр дүнгээр | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Эрсдэлийн судалгаа, дүн | “Эрсдэлийн удирдлага”-д суурилсан гаалийн хяналтын үр дүнг үндэслэн бүрдүүлэлтийн дараах шалгалтад | 2024.01.01-2024.12.10 | 94 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бүрдүүлэлтийн дараах шалгалтад хамрагдах ААНБ жагсаалтыг БДШГ-т хүргүүлж хамтран ажилласан байна. | | | шинжилгээний үр дүнгээр бүрдүүлэлтийн дараах шалгалтад хамрагдах ААНБ жагсаалтыг БДШГ-т хүргүүлсэн байна.<br>/I-IV улирал/ | хамруулахаар ГГХ-оос ирүүлсэн “Эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн хүсэлт”, “Шалгалтын үр дүнгийн санал”, “Зөрчилд холбогдсон байдал”, “Эрсдэлийн дүн шинжилгээний үр дүн” зэргийг үндэслэн 6 удаагийн дотоод зурвасаар 302 ААН-ийн жагсаалтыг хүргүүлсэн.<br>***БДШ оруулах ААН-ийн жагсаалт:***<br>1. 2024.01.25-ны өдрийн 2024/17 дугаартай дотоод зурвас. Цахим бүрдүүлэлтийн төвөөс ирүүлсэн эрсдэлийн шалгуурт оруулах тухай үндэслэлээр ААН-ийн хууль сахилтын түвшинг тодорхойлуулах 3 ААН,<br>2. 2024.02.06-ны өдрийн 2024/25 дугаартай дотоод зурвас. УБГГ-ын 2024.01.15-ний өдрийн 01/25 дугаар албан бичгээр эрсдэлийн шалгуурт оруулах тухай үндэслэлээр ААН-ийн хууль сахилтын түвшинг тодорхойлуулахаар нэг ААН,<br>3. 2024.02.21-ний өдрийн 2024/32 дугаартай дотоод зурвас. Улсын төсвийн орлогоос зайлсхийх эрсдэлт орчныг тодорхойлж, түүнийг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх зорилгоор аж ахуйн нэгж, иргэдийн гаалийн бүрдүүлэлт хийх үйл ажиллагааг итгэмжлэл олгон, төлөөлөгчөөр дамжуулан хийж буй гаалийн бүрдүүлэлтэд дүн шинжилгээг хийж 259 ААН,<br>4. 2024.04.08-ны өдрийн 2024/63 дугаартай дотоод зурвас. ЧХОУНБГГ-ын 2024.03.04-ний өдрийн 01/128 албан тоотоор БДШ- хамруулах тухай үндэслэлээр “Урьдчилсан бүрдүүлэлт хийсэн”, “Эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх, биологийн идэвхит бүдээгдэхүүн”, “Гар утас, мэдээллийн технологийн бүтээгдэхүүн” импортолдог 20 ААН,<br>5. 2024.05.10-ны өдрийн 2024/92 дугаартай дотоод зурвас. УБГГ-ын 2024.05.10-ны өдрийн 01/291 дугаар албан бичгээр БДШ- хамруулах тухай үндэслэлээр “Электрон тамхи” импортлогч 16 ААН,<br>6. 2024.06.04-ний өдрийн 2024/106 дугаартай дотоод зурвас. ЧХОУНБГГ-ын 2024.05.03-ны өдрийн 01/293 албан тоотоор БДШ- хамруулах тухай үндэслэлээр гаалийн зөрчилд холбогдсон 3 ААН.<br>7. ЭУХ-ийн 2024.06.19-ний өдрийн 2024/119 дугаартай дотоод зурвасаар БДШГ-аас ирүүлсэн 81/24 дугаартай | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дотоод зурвасаар ирүүлсэн 28 ААН-ийг шалгуурт оруулсан тухай бичгийн хариуг хүргүүлсэн.<br>Үүнээс 53 ААН-д шалгалт хийгдэж, 8,1 тэрбум төгрөгийн зөрчилд 2,47 тэрбум төгрөгийн торгууль ногдуулж, төсөвт төвлөрүүлэхээр акт үйлдэгдсэн. Шалгалтад хамрагдсан ААН-ээс:<br>- Зөрчил илэрсэн: 40 ААН<br>- Зөрчил илрээгүй: 12 ААН<br>- Хойшлогдсон: 1 ААН<br>- Дуусаагүй шалгалттай: 3 ААН<br>- Цагдаагийн байгууллагад шилжүүлсэн: 2 ААН<br>***БДШ-ын үр дүнгээр боловсруулсан эрсдэлийн шалгуурын тоо:***<br>БДШГ-аас 2024 онд 3 дотоод зурвас (81/24, 115/24, 185/24)-аар нийт 54 ААН-ийн эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн хүсэлт ирүүлсэн. Үүнээс 6 ААН нь 2023 оны эрсдэлийн шалгуурын программд хэрэгжиж байгаа тул 20 хяналтын хуудсаар, 48 эрсдэлийн шалгуурыг боловсруулсан. Үүнд:<br>- Заавал шалгах шалгуурт 12 хяналтын хуудсаар 40 ААН;<br>- Өндөр эрсдэлийн шалгуурт 4 хяналтын хуудсаар 4 ААН;<br>- Үл хамаарах шхалгуурт 2 хяналтын хуудсаар 2 ААН;<br>- Зөвшөөрөгдсөн шалгуурт 2 хяналтын хуудсаар 2 ААН-ийг эрсдэлийн шалгуурын программд оруулсан. | | |
| **Зорилт 4. “Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх”** | | | | | | | |
| 4. | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд оролцох ажлын хүрээнд гаалийн хяналтад эрсдэлийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох зорилгоор Гаалийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх журмыг шинэчлэн найруулж, төслийг боловсруулахад санал боловсруулна. | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Гаалийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх журмыг шинэчлэн найруулж, төслийг боловсруулахад санал өгсөн байна. /I-IV улирал/ | · Гаалийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх журмыг шинэчлэн найруулах төслийг боловсруулахад санал өгсөн.<br>· Эрсдэлийн мессеж сангийн программын хөгжүүлэлтэд санал өгсөн. | 2024.01.01-2024.12.10 | 93 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5. | Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд оролцох ажлын хүрээнд нэгжийн эрсдэлийг таньж тогтоож, сан үүсгэхэд хэлтсийн албан хаагчидтай хамтарч ажилласан байна. | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | 1.Нэгжийн эрсдэлийг таньж тогтоож, сан үүсгэсэн байна.<br>2.Эрсдэлд дүн шинжилгээ, үнэлгээ хийсэн байна. /I-IV улирал/ | Нэгжийн гүйцэтгэлийг давхардалгүй, орхигдуулахгүй, үр дүнтэй зохион байгуулахад учирч болзошгүй эрсдэлийг таньж, тогтоон түүнийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэхийн тулд "Эрсдэлийн удирдлагын хэлтсийн үйл ажиллагааны эрсдэлийн дүн шинжилгээ"-г хийхэд оролцсон.<br>Эрсдэлийн дүн шинжилгээг ДГБ-ын "Эрсдэлийн удирдлагын компендиум", Олон улсын стандартын байгууллагын "Эрсдэлийн удирдлагын зарчим ба стандарт", холбогдох үндэсний хууль тогтоомжтой уялдуулан хийж гүйцэтгэсэн. | 2024.01.01-2024.12.10 | 92 |
| 6. | ХАСХОМ-ийг мэдүүлсэн тухай баталгааны маягтыг хуулийн хугацаанд гаргаж, 100 хувь баталгаажуулсан байна. | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | ХАСХОМ, ХАСУМ мэдүүлсэн тухай баталгааны маягтыг хуулийн хугацаанд хүлээлгэн өгч, 100 хувь баталгаажуулсан байна.<br>/I-IVI улирал/ | 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр ХАСХОМ мэдүүлсэнг баталгаажуулж баталгааны маягтыг ЗУГ-т хүргүүлсэн.<br>Хөрөнгө, орлогод орсон өөрчлөлтийг 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр шинэчлэн баталгаажуулж, баталгааны маягтыг ЗУГ-т хүргүүлсэн. | 2024.01.01-2024.12.10 | 100 |
| 7. | Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь бүрэн биелүүлсэн байна. | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | 1.Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь бүрэн биелүүлсэн байна.<br>2.ХГГХ-д хүргүүлсэн үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь дүгнэж, ЗДАС программд үнэлсэн байна.<br>/I-IV улирал/ | ✓ Удирдлагаас ирүүлсэн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь хэрэгжүүлж, шийдвэрлэж ажилласан. Үүнд:<br>· ДГБ-аас зохион байгуулсан "Гарал үүсэл" Үндэсний сургалтап хамрагдаж, Барааны гарал үүслийн олон улсын хэм хэмжээ, стандарт болон түүнийг хэрхэн хэрэгжүүлж буй талаар Япон Улсын сайн туршлагаас суралцсан.<br>· Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой сургалтад хамрагдаж, худалдан авах ажиллагаанд оролцох сертификатын шалгалтад тэнцсэн.<br>· Экселийн ахисан түвшний сургалтад хамрагдаж, их өгөгдөлд дүн шинжилгээ хийх аргазүйг судалсан.<br>· Бичиг хэргийн e.doc программд бүртгэгдэж, ирсэн 11 албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэж, 21 дотоод зурвасыг ЗББНДБ-уудад хүргүүлж, хамтран ажилласан.<br>· ГЕГ-ын дотоод зохион байгуулалты нэгжүүдээс ирсэн 18 дотоод зурвасыг шийдвэрлэж, холбогдох судалгааг хийж, мэдээллийг хүргүүлж ажилласан.<br>· Койка ОУ-ын байгууллагын “Эрсдэлийн удирдлагын систем болон ачаа тээшний удирдлагын чадавхыг | 2024.01.01-2024.12.10 | 96 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бэхжүүлэх төсөл” (2025-2027 он)-ийн баг ГЕГ-ын ЗББНДБ-тай хийсэн уулзалтын тэмдэглэлийг хөтөлсөн.<br>✓ Өөрийн хариуцсан газар хороо болох УБГГ болон БиГГ-уудад эрсдэлийн удирдлагын хэлтсээс 2024 онд өгсөн 4 үүрэг даалгаврын биелэлттэй уншиж танилцан, арга зүй зөвлөмжөөр ханган дүгнэсэн.<br>✓ ГЕГ-ын ЗББНДБ-ын дунд 14 хоногт нэг удаа зохион байгуулагддаг 19 удаагийн мэдээллийн цагаар дараах мэдээллийг олж авсан.<br>1. Олон улсын гаалийн өдөр 2024<br>2. Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг шинэчлэн гаргахад анхаарах зарим асуудал” - АТГ<br>3. Үнэт цаас болон уул уурхайн бүтээгдэхүүний арилжаа - Монголын хөрөнгийн бирж<br>4. Дата менежмент, хэрэглээ, ач холбогдол - Интерактив ХХК<br>5. Хүн амын хоол тэжээлийн асуудал - Иргэдийн боловсролын төв<br>6. Ажлаас халшрах хам шинж- сэтгэл судлал - Байгууллагын сэтгэл судлаачдын хөгжлийн нийгэмлэг<br>7. Гаалийн байгууллагын дотоод хяналтын чиг үүрэг, ойлголтын талаар - ГЕГ-ын ДХАБХ<br>8. Эрүүл мэндийн даатгалын талаарх ойлголт - Эрүүл мэндийн даатгалын газар<br>9. Сансар, Шонхор зуслангийн танилцуулга - Сансар зуслангийн хөтөлбөр , маркетингийн алба<br>10. Эрсдэлийг удирдах байгууллагын соёл – ЭУХ, ЗУГ, МТГ<br>11. Архив, албан хэрэг хөтлөлтийн зохион байгуулалт – Архивын ерөнхий газар<br>12. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийн нөхцөл байдал, хэрэглэсэн хүнд илрэх шинж тэмдэг, таних, арга хууль эрх зүйн хариуцлага - ЦЕГ-ын Хар тамхитай тэмцэх газар<br>13. Эрүүл зөв хооллолт, дасгал хөдөлгөөн – Эмч Дугархүү Иж бүрэн шинжилгээ - Himnaera эмнэлэгийн төвийн албаны дарга Гү жон со | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 14. Авлигын гэмт хэрэг болон ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зарим асуудал – Нийслэлийн пррокурорын газар<br>15. Европын технологи болон барилга байгууламжийн үйл ажиллагаа - Стати Фикс" ХХК<br>16. Эрсдэлийг удирдах байгууллагын соёл - ЭУХ<br>17. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх тэмцэх хууль эрх зүйн орчин, олон улсын нөхцөл байдал, анхаарах асуудлууд - Монгол банкны дэргэдэх Санүүгийн мэдээллийн алба<br>18. Хөдөлмөрийн аюулгүйн байдал, эрүүл ахуйн тухай ерөнхий ойлголт - ХАБЭА-н чиглэлээр сургалт, судалгааны үйл ажиллагаа эрхэлдэг “Эрхэс сувд” ХХК<br>19. Гаалийн байгууллагын гадаад хамтын ажиллагааны 60 жилийн түүхийн альбом танилцуулах – ГХАХ<br>20. "Гаалийн албаны нууцын жагсаалт, Гаалийн улсын байцаагчийн үүрэг" – ХХ<br>✓ “Гаалийн цом-2024” системийн тэмцээнд гар бөмбөгийн төрөлд багаараа хүрэл медаль авсан.<br>✓ Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар өрнүүлж буй "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд ГЕГ болон ЗББНДБ-ын албан хаагчид 2024.05.18-ны өдөр Хөшигийн хөндийд хуваарийн дагуу мод тарьсан. | | |
| 8. | Ажлын цаг ашиглалтыг тухай бүр нүүр таних програмд бүртгүүлж, ажлын шаардлагаар илүү цагаар ажилласан цагийг гүйцэтгэлээр баталгаажуулсан байна. | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Ажлын цаг ашиглалт тасалдалгүй байна.<br>/I-IVI улирал/ | Тайлант хугацаанд өглөө орой бүр цаг бүртгэлийн нүүр таних төхөөрөмжид бүртгүүлж, уулзалт зөвлөгөөн, хэлэлцүүлэгт оролцсон үед чөлөө авах хүсэлтийг CERP-д тухай бүр оруулж, ажлын цаг ашиглалт тасалдалгүй болно.<br>2024.10.01-29-ны хугацаанд ээлжийн амралттай байсан болно. (нийт 217 хүн/өдөр – 2024.12.10-ны өдрөөр) | 2024.01.01-2024.12.10 | 91 |
| 9. | | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдаагүй цаг үеийн шинжтэй бусад арга хэмжээ, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажилласан | · Монгол Улс, БНСУ хоорондын Эдийн засгийн түншлэлийн хоёрдугаар шатны хэлэлцээнд ЭЗХЯ-ны 2024.05.09-ний өдрийн А/107 дугаар тушаалаар, гуравдугаар шатны хэлэлцээнд ЭЗХЯ-ны 2024.09.05-ны өдрийн А/207 дугаар тушаалаар Барааны гарал үүслийн дүрмийн ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажилласан. Гаалийн тарифын хөнгөлөлт эдлэх Барааны гарал үүслийн дүрэм, Барааны гарал үүслийн дүрмийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа гэсэн | 2024.01.01-2024.12.10 | 96 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Шаардлагатай тохиолдолд үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийг хэрэгжүүлж, тайлагнасан байна. | | | байдлыг тайлагнасан байна.<br>/I-IVI улирал/ | хоёр үндсэн хэсгээс бүрдсэн, одоогийн байдлаар 26 заалт тус бүрээр Талууд хэлэлцээний явцад эхний шатанд хэлэлцэгдсэн текст дэх асуудлаар хоёр талын байр суурийг илэрхийлэн, зарчмын хувьд нэмэх болон өөрчлөх саналыг хэлэлцэн тохирсон мөн Барааны гарал үүсэл, Бүтээгдэхүүний тусгай дүрмийг хэрэгжүүлэх асуудлаар хэлэлцэж тохирсон.<br>· ГЕГ-ын даргын 2024.06.06-ны өдрийн А/339 тушаалаар батлагдсан Гаалийн байгууллагын улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг хангуулахад чиглэсэн ажлын хэсгийн Судалгаа, дүн шинжилгээний багт ажиллаж, 8 удаагийн хурлаар барааны бүлгээр статистик үзүүлэлтээр барааны үнийн өсөлт, бууралтын шалтгааныг тогтоох зорилгоор 6 дүн шинжилгээг хийж, танилцуулж ажилласан.<br>· ГЕГ-ын даргын 2024.09.20-ны өдрийн “Говь” ХК, “АПУ” ХК, “Ханбогд Кашимер” ХХК-д гаалийн итгэмжлэл олгох шалгуурыг үнэлэх, баталгаажуулах ажлын удирдамжаар “Санхүүгийн чадавхи”-д баталгаажуулалт хийхэд тус 3 ААН-ийн гаалийн бүрдүүлэлт болон санхүүгийн үзүүлэлтэд шинжилгээ хийсэн. | | |

## Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Төрийн албанаас зохион байгуулж буй цахим сургалтад тухай бүр хамрагдах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Төрийн албанаас зохион байгуулж буй цахим сургалтад тухай бүр хамрагдсан байна. | **Төрийн албаны зөвлөлийн 7:4:10 сургалт:** Төрийн албаны зөвлөлийн 13 удаагийн цахим сургалтад хамрагдаж, дараах мэдээллийг олж авсан.<br>1. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн төслийн танилцуулга, хэлэлцүүлэг<br>2. "Дижитал шилжилт: Виртуал орчинд ажиллах" - МУИС-ийн Профессор А.Энхбаяр, VR AR MR<br>3. "Байгууллага, хувь хүний санхүүгийн төлөвлөлт, удирдлага" – МУИС-ийн зөвлөх, ЭЗШУ-ны доктор, профессор Л.Оюун | 2024.01.01-2024.12.10 | 95 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 4. "Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэг тодорхойлох судалгаа"<br>5. "Төрийн албаны үнэт зүйл (эрхэмж), үе хоорондын ялгаатай байдал" - МУИС-ийн ахлах багш, доктор Г.Мягмар<br>6. "Монгол төрийн зүтгэлтний хэв шинж (XX зууны эхэн үе)" - "Чингис хаан" музейн захирал, ШУА-ийн гишүүн, академич, түүхийн шинжлэх ухааны доктор С.Чулуун<br>7. "Төрийн албан хаагч нарт зориулсан эх хэл, бичгийн мэдлэг, чадвар, дадлын номын танилцуулга"<br>8. "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ын танилцуулга<br>9. "Хүний эрх хамгаалагчийг хамгаалах механизмын үйл ажиллагаа"<br>10. "Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгаа"<br>11. "Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль тогтоомжийг төрийн албан хаагч зөрчихөөс урьдчилан сэргийлэх нь"<br>12. Нийгмийн даатгалын хуулийн тухай (4 цуврал)<br>13. Төрийн албан хаагчийн ёсзүй (4 цуврал) | | |
| 2. | Англи хэлтэй албан хаагч сургалтад хамрагдах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Англи хэлний дунд шатны мэдлэгийг олж авсан байна. | Англи хэлтэй албан хаагч хөтөлбөрт хамрагдаж, англи хэлний дүрэм, эссэ бичлэгийн бүтэц, албан захидал бичих болон тухайлсан сэдвийн хүрээнд илтгэл танилцуулга хийх гэх зэргээр англи хэлний мэдлэгээ батжуулсан. | 2024.03.15-2024.12.10 | 95 |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

Газрын дарга байгаа ........М.Амарзаяа / М.Амл / 2024 оны 12.10

( Албан тушаал ) ( Нэр, гарын үсэг ) ( Огноо )

# ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ М.АМАРЗАЯАГИЙН 2024 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар
Нэгжийн нэр: Эрсдэлийн удирдлагын хэлтэс

## 1. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| **Зорилт 1. “Олон улсын худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хангах” зорилтын хүрээнд** | | | | | |
| 1. | Гаалийн хяналтад эрсдэл тооцож дүн шинжилгээ, судалгаа хийж, үр дүнг тооцох | 58 | 8 | 66 | |
| 2. | Гаалийн хяналтад эрсдэл тооцох ажлын хүрээнд эрсдэлийн профайл, эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн баяжилтыг хийх | 59 | 9 | 68 | |
| 3. | Эрсдэлийн судалгаа, дүн шинжилгээний үр дүнгээр бүрдүүлэлтийн дараах шалгалтад хамрагдах ААН-ийн жагсаалтыг БДШГ-т хүргүүлж хамтран ажиллах | 60 | 10 | 70 | |
| **Зорилт 4. “Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх”** | | | | | |
| 4. | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд оролцох ажлын хүрээнд Гаалийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх журмыг шинэчлэн найруулж, төслийг боловсруулахад санал боловсруулах | 55 | 8 | 63 | |
| 5. | Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд оролцох ажлын хүрээнд нэгжийн эрсдэлийг таньж тогтоож, сан үүсгэхэд хэлтсийн албан хаагчидтай хамтарч ажиллах | 57 | 8 | 65 | |
| 6. | ХАСХОМ-ийг мэдүүлсэн тухай баталгааны маягтыг хуулийн хугацаанд гаргаж, 100 хувь баталгаажуулах | 60 | 10 | 70 | |
| 7. | Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь бүрэн биелүүлэх | 58 | 8 | 66 | |
| 8. | Ажлын цаг ашиглалтыг тухай бүр нүүр таних програмд бүртгүүлж, ажлын | 55 | 7 | 62 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | шаардлагаар илүү цагаар ажилласан цагийг гүйцэтгэлээр баталгаажуулах | | | | |
| 9. | Шаардлагатай тохиолдолд үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийг хэрэгжүүлж, тайлагнах | 57 | 8 | 65 | |

## 2. МЭДЛЭГ, УР ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1. | Төрийн албанаас зохион байгуулж буй цахим сургалтад тухай бүр хамрагдах | 95 | 14.25 | |
| 2. | Англи хэлтэй албан хаагч сургалтад хамрагдах | 95 | 14.25 | |
| 3. | Тайванийн боловсролын яамны хятад хэлний курс | 85 | 12.8 | |
| **Дундаж оноо:** | | | **13.7** | |

## 3. ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ (НЭГЖИЙН ДАРГЫН ҮНЭЛГЭЭ)

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1. | Хандлага, ёс зүй | 6.1 | |
| 2. | Асуудал шийдвэрлэх | 6.3 | |
| 3. | Хариуцлагатай байдал | 6.4 | |
| 4. | Дүн шинжилгээ хийх | 6.8 | |
| 5. | Ажлын цаг ашиглалт | 6.0 | |
| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | | |
| Мэргэжлийн ур чадвар 1. Асуудал шийдвэрлэх, шийдвэр гаргах ур чадвар | | 6.0 | |
| Мэргэжлийн ур чадвар 2. Бүтээлч байдал | | 6.2 | |
| Мэргэжлийн ур чадвар 3. Судалгаа, дүн шинжилгээ, дүгнэлт хийх ур чадвар | | 7.0 | |
| **Дундаж оноо:** | | **6.35** | |

## 4. ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ (ХАМТ ОЛНЫ ҮНЭЛГЭЭ)

| Д/д | Хандлага, ёс зүй, ур чадвар | Хамт олны үнэлгээ (0-8) |
|---|---|---|

204

| | 1 | 2 |
|---|---|---|
| 1. | Хандлага, ёс зүй | 7.0 |
| 2. | Багаар ажиллах | 7.3 |
| 3. | Харилцаа | 7.1 |
| **Дундаж оноо: 7.1** | | |

## 5. ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно)* | **66.1** |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | **13.7** |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Нэгжийн даргын үнэлгээ)* | **6.35** |
| 4. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Хамт олны үнэлгээ)* | **7.1** |
| 5. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт *(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | **-** |
| **Нийт оноо =** (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо *(Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)* )- Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо | | **93.25** |

***Үнэлгээ өгсөн:***

***Нэгжийн дарга:***
Эрсдэлийн удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч .................................. (Д.Цэндсүрэн)

2024.12.10 *(огноо)*

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:***

***Төрийн жинхэнэ албан хаагч:***
Гаалийн улсын байцаагч .................................. (М.Амарзаяа)

2024.12.10. *(огноо)*

*Үнэлгээг хянасан :*

***Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:***
Дэд даргын албан үүргийг түр
орлон гүйцэтгэгч ................................ (Г.Энхтайван)

XII/20, 2024 .......... (огноо)

***Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:***
Хүний нөөцийн хэлтсийн
гаалийн улсын ахлах байцаагч ............................ (Ө.Тэгшээ)

2024.12.20 ........ (огноо)

***Үнэлгээг баталгаажуулсан:***

***Төсвийн шууд захирагч:***
Гаалийн ерөнхий газрын дарга ............................ (Р.Отгонжаргал)

.................................... (огноо)